



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/51/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Төлбөрийн акт.....	14
4.2 Албан шаардлага	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.07.24 № 2/107

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн авлагыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

- Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийгээгүй, тооллогын дүнг баталгаажуулаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана"

0050.0498

гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Оршин байх”, “Эрх ба үүрэг”, “Эрх ба үүрэг”, “Толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	137,534,855.59	113,395,002.81
33	АВЛАГА	37,906,108.81	3,789,856.03
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	6,401,090.57	3,217,642.79
33500	Бусад авлага	31,505,018.24	572,213.24
33510	Байгууллагаас авах авлага	31,505,018.24	572,213.24
34	УРЬДЧИЛГАА	100,000.00	0
34710	Урьдчилгаа тооцоо	100,000.00	0
34713	Цалингийн урьдчилгаа	100,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	99,528,746.78	109,605,146.78
35100	Түүхий эд материал	35,143,425.38	39,161,225.38
35110	Тусгай зориулалттай материал	35,143,425.38	33,867,225.38
35130	Эм боох материал	0	5,294,000.00
35400	Хангамжийн материал	55,755,321.40	62,013,921.40
35410	Бичиг хэргийн материал	5,266,752.00	3,450,152.00
35420	Аж ахуйн материал	41,972,769.40	42,647,969.40
35470	Бусад хангамжийн материал	8,515,800.00	15,915,800.00
35600	Мал амьтад	8,630,000.00	8,430,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,289,121,520.24	1,224,978,141.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,289,121,520.24	1,224,978,141.89
39200	Биет хөрөнгө	1,258,261,520.25	1,194,118,141.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,246,600,915.00	1,267,648,720.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-127,510,012.20	-206,429,075.88
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	182,750,965.53	199,222,865.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	-113,161,259.82	-129,183,378.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	112,439,870.78	114,271,870.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,958,875.24	-58,944,776.32
39217	Ном	7,099,916.20	7,531,916.20
39300	Биет бус хөрөнгө	30,859,999.99	30,859,999.99
39301	Програм хангамж	320,000.00	320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-310,000.01	-310,000.01
39303	Бусад биет бус хөрөнгө	30,850,000.00	30,850,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,426,656,375.83	1,338,373,144.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	28,100.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	28,100.00	0
41300	Өглөг	28,100.00	0
41360	Бусад өглөг	28,100.00	0
41361	Байгууллагад төлөх өглөг	24,100.00	0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,000.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,426,628,275.83	1,338,373,144.70
51	Засгийн газрын хувь оролцоо	1,426,628,275.83	1,338,373,144.70
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	767,534,111.81	767,534,111.81
51200	Хуримтлагдсан үр дүн	181,648,005.75	93,392,874.62
51210	Өмнөх үеийн үр дүн	-137,483,515.60	181,648,005.75
51220	Тайлант үеийн үр дүн	319,131,521.35	-88,255,131.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	477,446,158.27	477,446,158.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,426,656,375.83	1,338,373,144.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл / төгрөгөөр /
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,264,578,805.20	821,422,072.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	354,741,519.20	8,555,765.00
120	Нийтлэг татварын бус орлого	354,741,519.20	8,555,765.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	354,741,519.20	0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	354,741,519.20	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	5,315,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	3,240,765.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	909,837,286.00	812,866,307.74
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	784,854,000.00	720,415,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	784,854,000.00	720,415,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,997,386.00	19,959,032.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,549,586.00	19,309,032.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,447,800.00	650,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,985,900.00	72,492,175.74
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,985,900.00	72,492,175.74
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	945,447,283.85	909,677,203.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	945,447,283.85	909,677,203.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	866,592,564.35	824,394,188.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566,417,162.26	538,751,742.82
210101	Үндсэн цалин	566,417,162.26	538,751,742.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,287,034.64	69,974,697.00
210201	Тэтгэврийн даатгал	48,903,909.64	49,143,224.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,646,020.00	5,405,317.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,516,814.00	4,324,254.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,110,936.00	1,009,264.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,109,355.00	10,092,638.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,534,637.01	71,913,775.74
210301	Гэрэл, пахилгаан	4,127,171.51	3,651,900.74
210302	Түлш, халаалт	62,045,140.50	67,472,625.00
210303	Цэвэр, бохир ус	362,325.00	789,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,580,942.80	16,665,625.00
210401	Бичиг хэрэг	2,773,200.00	6,698,060.00
210402	Тээвэр, шатахуун	6,747,342.80	1,538,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	532,500.00	491,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	315,000.00	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,080,900.00	7,787,265.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	392,000.00	0
210408	Бараа материал акталсны зардал	7,740,000.00	0
2105	Нормативт зардал	21,948,920.00	19,115,295.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,936,400.00	5,674,595.00
210502	Хоол, хүнс	20,012,520.00	13,440,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,691,031.00	1,980,320.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	902,920.00
210604	Урсгал засвар	7,691,031.00	1,077,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,178,000.00	464,700.00
210702	Дотоод албан томилолт	3,178,000.00	464,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,488,300.00	1,600,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,023,300.00	1,100,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,466,536.64	103,927,083.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,828,400.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,255,110.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	85,383,026.64	103,927,083.35

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,854,719.50	85,283,014.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,674,532.40	39,254,288.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,666,672.00	20,123,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,911,116.00	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,629,370.00	19,130,988.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,467,374.40	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,289,476.49	178,044.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,289,376.49	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	100	178,044.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,890,710.61	45,850,682.96
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,890,710.61	45,850,682.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	319,131,521.35	-88,255,131.13
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	319,131,521.35	-88,255,131.13

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	909,837,286.00	812,966,307.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	100,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	100,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	909,837,286.00	812,866,307.74
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	784,854,000.00	720,415,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	784,854,000.00	720,415,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,997,386.00	19,959,032.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,549,586.00	19,309,032.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,447,800.00	650,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,985,900.00	72,492,175.74
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,985,900.00	72,492,175.74
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	894,251,088.00	809,430,407.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	894,251,088.00	809,430,407.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	815,515,118.50	724,147,392.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566,806,426.99	528,010,292.04
210101	Үндсэн цалин	395,005,693.74	404,227,238.62
210102	Нэмэгдэл	90,514,880.32	88,780,137.95
210104	Урамшуулал	65,030,406.92	35,002,915.47
210105	Гэрээт ажлын хөлс	16,255,446.01	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,672,800.00	77,532,700.00
210201	Тэтгэврийн даатгал	56,132,700.00	57,780,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,635,100.00	4,938,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,508,000.00	3,950,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,127,000.00	987,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,270,000.00	9,875,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,696,523.51	72,032,275.74
210301	Гэрэл, цахилгаан	4,127,171.51	3,651,900.74
210302	Түлш, халаалт	55,144,702.00	67,472,625.00
210303	Цэвэр, бохир ус	424,650.00	907,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,820,469.00	9,865,340.00
210401	Бичиг хэрэг	1,468,800.00	954,600.00
210402	Тээвэр, шатахуун	6,267,267.00	1,538,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,953,500.00	1,719,040.00
210404	Ном, хэвлэл	274,302.00	43,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	475,000.00	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,381,600.00	5,460,000.00

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2105	Нормативт зардал	29,921,355.00	28,636,215.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,490,800.00	5,323,595.00
210502	Хоол, хүнс	19,556,855.00	13,440,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,873,700.00	9,871,920.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,738,836.00	3,057,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	800,000.00
210602	Тавилга	0	396,000.00
210604	Урсгал засвар	25,738,836.00	1,861,900.00
2107	Томилолт, зочны зардал	3,178,000.00	464,700.00
210702	Дотоод албан томилолт	3,178,000.00	464,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,274,148.00	2,094,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,824,148.00	1,354,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,406,560.00	2,453,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,900,000.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,506,560.00	2,453,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,735,969.50	85,283,014.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,555,782.40	39,254,288.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,547,922.00	20,123,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,911,116.00	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,629,370.00	19,130,988.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,467,374.40	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,289,476.49	178,044.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,289,376.49	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	100	178,044.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,890,710.61	45,850,682.96
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,890,710.61	45,850,682.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	15,586,198.00	3,535,900.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	15,586,198.00	3,535,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,586,198.00	3,535,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,586,198.00	3,535,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,586,198.00	3,535,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-15,586,198.00	-3,535,900.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	/ төгрөгөөр /	
				Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	767,534,111.81	477,446,158.27	-137,483,515.60	1,107,496,754.48
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	767,534,111.81	477,446,158.27	-137,483,515.60	1,107,496,754.48
9	Тайлант үеийн үр дүн	0	0	319,131,521.35	319,131,521.35
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	767,534,111.81	477,446,158.27	181,648,005.75	1,426,628,275.83
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	767,534,111.81	477,446,158.27	181,648,005.75	1,426,628,275.83
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	767,534,111.81	477,446,158.27	181,648,005.75	1,426,628,275.83
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-88,255,131.13	-88,255,131.13
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	767,534,111.81	477,446,158.27	93,392,874.62	1,338,373,144.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	844,163,800.00	747,056,592.78	97,107,207.22	88.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	844,163,800.00	747,056,592.78	97,107,207.22	88.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	818,908,900.00	726,933,292.78	91,975,607.22	88.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	557,979,600.00	527,910,292.04	30,069,307.96	94.6
210101	Үндсэн цалин	429,257,900.00	404,127,238.62	25,130,661.38	94.1
210102	Нэмэгдэл	93,929,300.00	88,780,137.95	5,149,162.05	94.5
210104	Урамшуулал	34,792,400.00	35,002,915.47	(210,515.47)	100.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,532,700.00	77,532,700.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	57,780,800.00	57,780,800.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,938,000.00	4,938,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,950,300.00	3,950,300.00	-	100.0
210204	Ажил үйлдлийн даатгал	987,700.00	987,700.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	9,875,900.00	9,875,900.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,748,700.00	72,032,275.74	50,716,424.26	58.7
210301	Гэрэл, цахилгаан	6,371,800.00	3,651,900.74	2,719,899.26	57.3
210302	Түлш, халаалт	115,414,900.00	67,472,625.00	47,942,275.00	58.5
210303	Цэвэр, бохир ус	962,000.00	907,750.00	54,250.00	94.4
2104	Хангамж, бараа материалын зардал	11,707,400.00	10,297,340.00	1,410,060.00	88.0
210401	Бичиг хэрэг	954,600.00	954,600.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,538,500.00	(38,500.00)	102.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,924,900.00	1,719,040.00	205,860.00	89.3
210404	Ном, хэвлэл	627,900.00	475,200.00	152,700.00	75.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	1,240,000.00	150,000.00	1,090,000.00	12.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,460,000.00	5,460,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	37,571,200.00	28,636,215.00	8,934,985.00	76.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,703,600.00	5,323,595.00	380,005.00	93.3
210502	Хоол, хүнс	21,705,700.00	13,440,700.00	8,265,000.00	61.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,161,900.00	9,871,920.00	289,980.00	97.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,924,600.00	6,161,800.00	762,800.00	89.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	800,000.00	-	100.0
210602	Тавилга	3,500,000.00	3,499,900.00	100.00	100.0
210604	Урсгал засвар	2,624,600.00	1,861,900.00	762,700.00	70.9
2107	Томилолт, зочны зардал	464,700.00	464,700.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	464,700.00	464,700.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,445,000.00	1,444,950.00	50.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	705,000.00	704,950.00	50.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,535,000.00	2,453,020.00	81,980.00	96.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,535,000.00	2,453,020.00	81,980.00	96.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,254,900.00	20,123,300.00	5,131,600.00	79.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,254,900.00	20,123,300.00	5,131,600.00	79.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,757,900.00	20,123,300.00	4,634,600.00	81.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	497,000.00	-	497,000.00	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	844,163,800.00	747,056,592.78	97,107,207.22	88.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	720,415,100.00	674,564,417.04	45,850,682.96	93.6
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	720,415,100.00	674,564,417.04	45,850,682.96	93.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	123,748,700.00	72,492,175.74	51,256,524.26	58.6
320001	Орон нутгийн төсвөөс	123,748,700.00	72,492,175.74	51,256,524.26	58.6
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	443	443	0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45	45	0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	34	34	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10	10	0	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	352	352	0	100.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	352	352	0	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	352	352	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,997,286.00	19,959,032.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,997,286.00	19,959,032.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,456,800.00	650,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,456,800.00	650,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,456,800.00	650,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,540,486.00	19,309,032.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,540,486.00	19,130,988.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,911,116.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,629,370.00	19,130,988.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	178,044.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	178,044.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	60,997,286.00	19,959,032.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,997,286.00	19,959,032.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,549,486.00	19,309,032.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,447,800.00	650,000.00
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Д.Цэцэгээ, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Дорждагва нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Багш бүр ажлын байрандаа тасралтгүй хөгжиж хэрэгцээт хөтөлбөр боловсруулан суралцагчдын сурлагын амжилт чанар, сурах арга барилд ахиц гарган, сурах хөгжих таатай орчин бүрдүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 576,685.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,650.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,055.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 9,551.6 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88,283.2 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	137,534.9	113,395.0	(24,139.9)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	37,906.1	3,789.9	(34,116.3)
Урьдчилгаа	100.0	-	(100.0)
Бараа материал	99,528.7	109,605.1	10,076.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,289,121.5	1,224,978.1	(64,143.4)
Үндсэн хөрөнгө	1,580,061.7	1,619,845.4	39,783.7
Хуримтлагдсан элэгдэл	(290,940.1)	(394,867.2)	(103,927.1)
Нийт хөрөнгө	1,426,656.4	1,338,373.1	(88,283.2)
Өр төлбөр	28.1	-	(28.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,426,628.3	1,338,373.1	(88,255.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,426,656.4	1,338,373.1	(88,283.2)

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 34,116.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны 9,885.0 мянган төгрөгийн ухаалаг самбарын, 21,047.8 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулсан бол хувь хүнээс авах 572.2 мянган төгрөгийн авлага барагдаагүй, тайлант онд ажиллагсадтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн 3,217.6 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 109,605.1 мянган төгрөг болж 10,076.4 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал дансны үлдэгдэл 5,294.0 мянга, бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 7,400.0 мянган төгрөгөөр тус тус өмнөх оноос нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,619,845.4 мянган төгрөг болж өмнөх оноос 39,793.7 мянган төгрөгөөр өссөн нь 3,535.9 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй 5,315.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, өмнөх оны авлагаар бүртгэсэн 30,932.8 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,338,373.1 мянган төгрөг болж 88,255.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 88,255.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт зарлагыг 1,060,443.8 мянга, санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,060,443.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 249,278.0 мянган төгрөгөөр бууруулж 811,165.8 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг 844,163.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 720,415.1 мянга, орон нутгийн төсвөөс 72,492.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 747,056.6 мянган төгрөгийг зарцуулж 45,850.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 747,056.6 мянган төгрөг буюу 88.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 30,069.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 50,716.4 мянга, хангамж бараа материалын зардлыг 1,410.1 мянга, нормативд зардлыг 8,935.0 мянга, үдийн цайны зардлыг 4,634.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Байгууллагын тооллогын комисс нь эд хөрөнгийг данс бүрээр хөрөнгийн журналаар тоолоогүй, ажилтнуудын картаар тоо ширхгээр тоолсон нь бүртгэлтэй хөрөнгүүдийг ажилтнуудын картад бүрэн бүртгэж тоологдсон эсэхийг нотлох боломжгүй, нягтлан бодогч

тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж захирлын тушаалаар баталгаажуулаагүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн авлагыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд нийт 69 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 909,677.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 35,770.1 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2021 онд нийт 1,086,278.8 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 127,519.8 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроосон, 4-р улирлын төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 811,165.8 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 32,998.0 мянган төгрөг нэмж 720,415.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 123,748.7 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 747,056.6 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 11.5 хувийн хэмнэлт гаргасан. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад урсгал зардлын төсвийг 247,509.0 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 38,857.5 мянган төгрөг хасаж 208,651.5 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 141,613.6 мянган төгрөг зарцуулсан байгаа нь анх батлагдсан төсөвт 42.8 хувийн хэмнэлт гаргасан.

- Бичиг хэргийн зардлыг 954.6 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 954.6 мянган төгрөг зарцуулсан байна.

- Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 139,756.2 мянган төгрөгөөр, тодотголоор 122,748.7 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 72,032.3 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 67,723.9 мянган төгрөг буюу 48.5 хувь хэмнэсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 40,187.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 23,348.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 7807.7 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 9,885.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснөөс Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилттэй холбоотой 4,335.2 мянга, өмнөх онд үүссэн 572.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлага биелээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2001-2002 онд нярваар ажиллаж байсан Ч.Батсүхтэй холбоотой 572.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлага өгсөн ч авлага барагдаагүй байна.

Мөн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 131/ШШ2020/00848 тоот захирамж, аймгийн Засаг даргын 2020 оны А/784 тоот захирамжийн дагуу сургуулийн захирал Д.Цэцгээд ажилгүй байсан хугацааны цалин 4335.2 мянган төгрөг олгосон зөрчлийг арилгаж төрд учирсан хохирлыг барагдуулах албан шаардлагыг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд өгсөн ч хэрэгжээгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,940.2 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 5736.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 203.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлээ.

4.1 Төлбөрийн акт

1. Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар хөрөнгийг түүвэрлэн шалгахад 2019 онд "Хөгжил дэвшил нэгдэл" ХХК- иас 2519.0 мянган

төгрөгөөр нормын хувцас худалдан авахаар санхүүжилт олгосон ч гүйцэтгэгч хөрөнгийг нийлүүлээгүй байхад орлого авч хөрөнгөнд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Орших байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэгч “Хөгжил дэвшил нэгдэл” ХХК- иар 2,519.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Цалингийн зардлаас ажилчдаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын хэлтэст 3,217.6 мянган төгрөгөөр илүү шилжүүлэн авлагаар бүртгэж төсөвт зардлыг хэтрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс илүү төлсөн 3,217.6 мянган төгрөгийг суутган тооцож төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

4.2 Албан шаардлага

1. Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2021 онд нийт 1,086,278.8 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 127,519.8 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроосон, 4-р улирлын төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг 7 хоногийн дотор мэдээлнэ” заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2. Байгууллагын тооллогын комисс нь эд хөрөнгийг данс бүрээр хөрөнгийн журналаар тоолоогүй, ажилтнуудын картаар тоо ширхгээр тоолсон нь бүртгэлтэй хөрөнгүүдийг ажилтнуудын картад бүрэн бүртгэж тоологдсон эсэхийг нотлох боломжгүй, тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж захирлын тушаалаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Оршин байх”, “Эрх ба үүрэг”, “Эрх ба үүрэг”, “Толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Байгууллагын өмч хөрөнгийн тооллогыг хууль, тогтоомжийн дагуу хийж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

3. Ажиллагсдын цалинг 2021 оны 05, 06, 07, 09 дүгээр саруудад 203.6 мянган төгрөгөөр Нийгмийн даатгалын хэлтэст илүү мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2021 оны 203.6 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль	5	5940.2			2	2519.0	3	203.6	-	-

_____оОо_____